



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/570

Мөрөн сум

Отор нүүдлийг орон нутгийн нөөц боломжид  
тулгуурлан өвөлжүүлж, хаваржуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.3, 32.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн 2024-2025 оны Өвөл, Хаврын бэлчээрийн даац Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс баг бүрт, бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ болон бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэлд үндэслэн бэлчээрийн даацыг тооцсон байна. Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл аймгийн нийт нутгийн: 42% - бэлчээрийн нөөцтэй, 14% - бэлчээр хүрэлцээтэй, 28% - даац 1-3 дахин хэтэрсэн, 10% - даац 3-5 дахин хэтэрсэн, 6% - даац олон дахин хэтэрсэн байна. Өөрөөр хэлбэл өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 60 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 40 гаруй хувьд хэтэрсэн. Бэлчээрийн даац олон дахин хэтэрч гарсан сумдад Цагаан-Уул сумын Шарга, Бүрэнтогтох сумын Их-Уул, Төмөрбулаг сумын Тээл, Нарийн, Тосонцэнгэл сумын Тээл, Сэлэнгэ, Түнэл сумын Алтгана, Баян-Эрхт багийн нутаг хамрагдаж байна. Харин Баянзүрх, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Төмөрбулаг, Галт, Жаргалант, Тосонцэнгэл сумдын зарим багийн нутгаар 3-5 дахин хэтэрч гарсан тул өвөл, хаврын бэлчээр хүрэлцээгүй сумдаас очиж буй отор нүүдлийг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан өвөлжүүлж, хаваржуулах, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн тусламж үйлчилгээнд хамруулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Сумдаас отор нүүдэл хийх гэж байгаа өрхүүдэд тулгамдаж буй асуудлыг хүлээн авч, хууль тогтоомжийн хүрээнд хариу арга хэмжээ авч шийдвэрлэн ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ